



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 30 өдөр

Дугаар АН/16

Хажуу шинэ ус

Дуудлага худалдаа зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Говь-Угтаал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу иргэн, аж ахуй нэгж байгууллагад худалдаа үйлчилгээ зориулалтаар шинээр эзэмшүүлэх газрын дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Өлзийтогтох (Тамгын газрын дарга)

Хөтлөгч: Г.Булган (Нийгмийн даатгалын байцаагч)

Тэмдэглэл хөтлөгч: Б.Хорол(Газрын даамал)

2. Газар эзэмших эрхийн дуудлага худалдаа явуулах ажлын журам, зааврыг баримтлан ил тод, нээлттэй явуулахыг ажлын хэсгийн ахлагч (Н. Өлзийтогтох)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө. МӨНХ-АМГАЛАН

482201116